



---

## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

---

**ЗОРИЛТ:** ХАА-н салбарт ИНБ-дын санаачилгыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Архангай аймгийн Цэцэрлэг сумын Малчдын Хоршоонд түүхий эдийн агуулах барих ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.

### АГУУЛГА:

---

Франц улсад төвтэй Хил Хязгааргүй Малын эмч нар ба Агрономчид (AVSF) ОУБ нь Европын Холбооны санхүүжилтээр “Хөдөөгийн эдийн засгийн хөгжилд жендерийн тэгш оролцоог хангах” (ИМПАКТ) төслийг GERES ОУБ, Монголын Эмэгтэйчүүдийн сан (МОНЭС)-тай хамтран хэрэгжүүлж байна.

“ИМПАКТ” төсөл нь эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг нэвтрүүлж, тогтвортой ноолуур, органик хүнсний ногоо тариалалтын сайн туршлагуудыг бий болгох замаар үйлдвэрлэгч эмэгтэйчүүдийг чадваржуулж, шийдвэр гаргах үйл явцад оролцох, орон нутгийнхаа эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад нь дэмжлэг үзүүлдэг.

Тогтвортой ноолуур дэд төслийн хүрээнд Архангай аймгийн Цэцэрлэг суманд 14x8 м-ийн харьцаатай ердийн салхивчтай, халаалтгүй, **түүхий эдийн агуулах, хашааны хамт барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна.**

### СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

---

- ✓ Дээрх ажлыг гүйцэтгэх эрх бүхий компани, хуулийн этгээд байх
- ✓ Урьд нь барилгын ажил гүйцэтгэж хүлээлгэж өгч байсан туршлагатай байх
- ✓ Чадварлаг, мэргэжлийн ажилчидтай байх
- ✓ Машин механизм, шаардлагатай багаж тоног төхөөрөмжтэй байх /Түрээс байж болно/
- ✓ Санхүүгийн чадавхитай байх

- ✓ Түүхий эдийн агуулахын MNS 5364:2011 стандартыг мөрдлөг болгох
- ✓ Агуулахын барилгын зураг төслийг гүйцэтгэлдээ оруулсан байх
- ✓ Гүйцэтгэлийг 1 сараас 45 хоногт дуусгах боломжтой байх
- ✓ Орон нутгаас олдоцтой, сайн чанарын барилгын материал ашиглах
- ✓ Баталгаат хугацаа өгөх

**Сонирхсон аж ахуйн нэгж, байгууллага 14x8 м-ийн харьцаатай түүхий эдийн агуулахын барилгын зураг төсвийг хийн доорх цахим хаягаар ирүүлнэ үү.**

### **СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ХУВААРЬ**

---

- 2021 оны 8 сарын 16: Сонгон шалгаруулалтын урилга, мэдээлэл түгээх
- 2021 оны 8 сарын 30: Санал хүлээн авах эцсийн хугацаа ба сонгон шалгаруулалт
- 2021 оны 8 сарын 30- 9 сарын 3: Шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ хийх
- 2021 оны 10 сарын 29: Агуулахын барилга хүлээж авах

#### **Холбоо барих:**

Хил Хязгааргүй Малын Эмч нар ба Агрономчид /AVSF/ ОУБ-ын Архангай аймаг дахь салбар

Хаяг: Эрдэнэбулган сум, 3-р баг, Бөх билэгтийн гудамж “Ар арвижин дэлгэрэх” хоршооны байр 2 давхар

Утас: 88096422, 99337677,

Цахим хаяг: [m.ariuntungalag@avsf.org](mailto:m.ariuntungalag@avsf.org)  
[s.ganbat@avsf.org](mailto:s.ganbat@avsf.org)